

БАТЛАВ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ДҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

С.ЦОГТГЭРЭЛ

ХОГ ХАЯГДАЛ АНГИЛАН ЯЛГАХ ТӨВИЙН ЖИШИГ ЗУРАГ, ТӨСӨВ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР
/ДАВТАН ЗУРАГ/

	Үндэслэл	“Алсын хараа-2050” 6.4.19, 6.4.20, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2.5.3, 6.4.6, 9.2.2, Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний 5.1.9 дэх, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.3 дахь заалт.
1	Зураг төсөл зохиох үе шат	1 үе шаттай • Загвар зураг • Ажлын зураг Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
2	Хог ангилан ялгах төвийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн бүрэлдэхүүн	1. Ангилан ялгах төвийн барилга байгууламж дараах шаардлагыг хангасан байна. 1.1. Барилга байгууламж, гадна орчны төлөвлөлтөд тавих шаардлага • Барилга, байгууламжийг норм ба дүрмийн дагуу барьсан байна. • Цахилгаан эрчим хүчийг төвийн болон нар салхины эх үүсвэрээр шийдсэн байна. • Цэвэр, бохир усны төвлөрсөн болон хэсгийн системд холбогдсон байна. • Халаалтын систем нь төвлөрсөн болон хэсгийн шугамд холбогдсон байна. • Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг хүрэлцээтэй байна. • Галын аюулгүй байдлын дүрэмд нийцсэн байна. • Хог хаягдал хүлээн авах хаалга нь ангилж, шахаж нягтруулсан ачаа зөөвөрлөх хаалганаас тусдаа орох, гарах урсгалтай байна. • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замтай байна. • Хаягдал түүхий эд хүлээн авах, бэлэн болсон ачааг ачуулах зам талбайтай, ажиллагсдын амрах танхим, ариун цэврийн өрөө, шүршүүр, гар угаах газар, хувцас солих болон ажлын өрөөтэй байна. • Өргөгч, тээвэрлэх машин чөлөөтэй хөдлөх, маневр хийх талбайтай байна. 1.2. Гадна орчин • Гадна орчинд ачаа хүлээн авах, ачих, зорчих зориулалтын талбайтай, чиглүүлэх, зохицуулалт бүхий замын хязгаарлах зураас, пайз тэмдэг хийсэн байна. • Автомашины зогсоолтой, зам талбайг цардсан, ногоон байгууламж бүхий эко орчин бүрдүүлсэн байна. • Үйлчилгээний нэр хүндийг илэрхийлэх лого тэмдэг бичиглэл бүхий хаягийг шөнийн цагт гэрэлтэж харагдахуйц түвшинд байршуулсан байна.

		<p>1.3 .Дотоод орчны төлөвлөлтөд тавигдах шаардлага Үйлдвэрлэлийн талбайн төлөвлөлт</p> <ul style="list-style-type: none"> • Дахивар хүлээн авах, түр хадгалах, гараар ангилан ялгаж нягтруулах шугам руу шилжүүлэх савлалт, нягтруулсны дараа дахивраа шошгожуулж талбайд зөөж хураах гэсэн технологийн нэг чигийн урсгалтай байна. • Шахаж нягтруулсан дахивраа хурааж хадгалах талбайтай, өргөгч машин чөлөөтэй маневр хийх зам талбайтай байна. <p>Үйлдвэрлэлийн бус талбайн төлөвлөлт</p> <ul style="list-style-type: none"> • Дахивар хүлээн авах, хадгалах, дахин боловсруулах үйлдвэрүүд рүү ачуулахад бэлтгэх талбай, операторын өрөөтэй байна. • Ажилчдад зориулсан ахуй хангамжийн өрөөтэй байна. <p>1.4. Тоног төхөөрөмж, тэмдэг тэмдэглээ дахиврын тээвэр логистикийн төвийн технологи ажиллагаанд нийцсэн зориулалтын тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> • Хяналтын, баталгаажсан хэмжүүр /пүүлэгч/, хэмжих хэрэгсэлтэй байна. • Постерминал/ Барааны зураасан код уншигчтай Бүртгэх систем бүхий хяналтын тоног төхөөрөмжтэй байна. • Төлбөр тооцооны карт унших машинтай байна. • Хөдөлмөр хөнгөвчилсөн, өндөр бүтээмжтэй конвейрын систем бүхий хэвтээ пресслэгч машинтай байна/+30-40 хэмд найдвартай ажиллах хийн хоолой, хөргөлтийн системтэй, аюулгүй ажиллагааны стандарт шаардлагыг хангасан битүүмжлэлтэй байх/. • Үйлдвэрлэлийн болон гадна талбайд ажиллах зориулалт бүхий ачих, буулгах машинаар үйлчлэх боломжтойгоор төлөвлөнө . • Талбайн бүхий л хэсэг, үйлдвэрлэлийн шат дамжлага, агуулах хонгилд тамхи татах, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглосон тэмдэглэгээ байршуулсан байна. • Хяналтын камертай байна.
3	Тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Харуул хамгаалалт, дохиоллын системтэй байх - Хэмжих хэрэгсэл бүхий бүртгэлийн байртай байх - Үйл ажиллагааны хяналтын системтэй байх - Үйл ажиллагаанаас үүсэх агаар, хөрс, усанд ялгарах ялгарлыг хянах системтэй байх - Төвлөрсөн инженерийн дэд бүтцэд холбогдсон эсхүл хэсэгчилсэн инженерийн байгууламжтай байх <p>Барилга, байгууламжийг газар хөдлөлтийн 4 балл /6,7,8,9/, Гадна агаарын температур нь -30°C, -40°C тус тус тооцож, иж бүрэн ажлын зураг хийнэ.</p>
4	Зураг төсөл, баримт бичгийн иж бүрдэл:	<p>Бэлтгэл ажил:</p> <ul style="list-style-type: none"> - Архитектур төлөвлөлтийн даалгавар - Байр зүйн дэвсгэр - Техникийн нөхцөлүүд /Ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамж, цахилгаан хангамж, холбоо дохиолол/; - Барилгын зураг төсөлд галын аюулгүй байдлын хяналт дүгнэлт; - Магадлалын нэгтгэсэн дүгнэлт <p>Ажлын зургийн иж бүрдэл:</p>

		<ul style="list-style-type: none"> - Батлагдсан загвар зураг - Батлагдсан ажлын зураг - Нүүр хуудас/батлагдсан/ - Орчны ерөнхий төлөвлөгөө, зай хэмжээ өндөржилт, картограмм - Барилга архитектур, технологийн зураг; - Барилга бүтээц/Бүтээцийн тооцоо/; - Халаалт,агаар сэлгэлт; - Хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг; Цэвэр бохир ус; - Дотор холбоо дохиолол - Автоматик - Батлагдсан ажлын зураг - Гадна цахилгаан - Дулаан хангамж - Ус хангамж, ариутгах татуурга - Гадна холбоо дохиолол - Барилгын нэгдсэн төсөв. <p>Зураг төсөлд тавигдах шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> - Барилгын гадна орчны тохижилтын элементүүдийг норм, дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлыг 3D буюу хэмжээст зураглалаар гүйцэтгэх. Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага: <p>Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх</p> <ul style="list-style-type: none"> - Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн WGS-848 UTM буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх. - Батлагдсан зураг төсөл, загвар зураг болон ажлын зураг төсөл, төсвийг холбогдох баримт бичгүүдийн хамт эх хувь-1, хуулбар хувь-3 хэвлэмээр, / Pdf /хэлбэрээр CD-д бичиж 1 хувь хүлээлгэн өгнө.
5	Барилгын үндсэн үндсэн бүтэц	<p>1.1. Барилга 1500-3000 хүн амтай суурьшлийн бүсэд зориулагдсан байна.</p> <p>1.2. Барилга 3000-5000 хүн амтай суурьшлийн бүсэд зориулагдсан байна.</p>
6	Санхүүжүүлэгч байгууллага	Улсын төсөв
7	Захиалагч	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
8	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p>Хууль тогтоомжууд:</p> <ul style="list-style-type: none"> - Хот байгуулалтын тухай хууль - Барилгын тухай хууль - Хог хаягдлын тухай хууль - Газрын тухай хууль - Эрчим хүчний тухай хууль - Усны тухай хууль <p>Норм, нормативууд:</p> <ul style="list-style-type: none"> - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт/ БнбД30.1.04/; - Барилгын инженер геологийн ажил /БнбД30.1.04/; - Барилгын геодезийн ажил /Бнбд 11-08-06/; - Барилга байгууламжийн галын аюулгүй байдал” /Бнбд 21-01-02/; - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм” /Бнбд 21-01-02/; - Барилгын захиалагчийн дүрэм; - Барилгын бүтээц ба буурийн найдваршил; - Ерөнхий шаардлага /Бнбд20-01-11/;

		<ul style="list-style-type: none"> - Барилга, байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох /БНбд50-01-16/; - Ачаалал ба үйлчлэл / /БНбд 20-04-17/; - Цутгамал бетон төмөр бетон бүтээц” /БНбд 52-02-03/; - “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” /БНбд 22-01-21/; - “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт” /БНбд 23-01-09/; - “Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж” БНбд 40-01-14/; - “Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж” /БНбд 40-02-16/ - “Дотор сантехникийн систем” /БНбд 40-06-16/ - Цахилгаан техникийн ажил/ БНбд 3.05.06-90/ - Автоматжуулалтын систем / БНбд 3.05.07-90/; - Барилгын бүтээц, ажлын төрлөөр төсвийн суурь норм, түүний хавсралтуудыг боловсруулах, хэрэглэх дүрэм / БНбд 81-10-04/*-10/ - Барилгын төсөв зохиох дүрэм /БНбд 81-95-12*/20/ - Барилгын орчны тохижилтын ажил / БНбд 3.01-06-90 / - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хий дүрэм /ЗГ 2019 оны 108 тогтоол/ <p>Стандартууд:</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрын орчин.Эрүүл ахуйн шаардлага” MNS4990:2015; - Ажлын байрны бичиг цаг уурын эрүүл ахуйн хэмжээ MNS 126016-91; - Ажлын байрны хүчдэлийн түвшин” MNS126097-918 MNS126098-918 MNS 126101-091
--	--	--